



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/209

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.1, 19 дүгээр зүйлийн 19.1.1, 19.4 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Шинэ сэргэлтийн бодлого” батлагдсантай холбогдуулан “Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т холбогдох нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн боловсруулж, батлуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүдэд: Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн
Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн
Цэргийн штабын дарга, хурандаа
Цагдаагийн газрын дарга
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, хэлтэс, албаны дарга
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, албаны дарга
Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга, ахлах мэргэжилтэн
Эрүүл мэндийн газрын дарга, хэлтсийн дарга
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, хэлтсийн дарга
Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга, ахлах мэргэжилтэн
Онцгой байдлын газрын дарга
Орон нутгийн өмчийн газрын дарга
Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн
Статистикийн хэлтсийн дарга
Татварын хэлтэсийн дарга, хэлтсийн дарга
Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга
Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга, хэлтсийн дарга

6717010033

Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга

2. Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийг холбогдох хууль
тогтоомжид нийцүүлэн боловсруулж, 2023 оны 2 дугаар улиралд багтаан
таницуулахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН